**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

**“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын “Эрдэнэт медикал эмнэлэг” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан**

**Аудитын код: ОРА-2026/006/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Орхон аймаг<br>2026 он | Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва<br>Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Буян-ундрах<br>Утас: 70355805 Цахим хаяг: Buynundrakhb@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Г.Оргилмөрөн<br>Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn<br>Аудитор: Ж.Наранчимэг<br>Утас: 70350757 Цахим хаяг: naranchimegj@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт** /Баталгаажсан хувийг оруулах/

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.03.13 № 87

танай ____________-ны № ____________-т

ЭРДЭНЭТ МЕДИКАЛ ЭМНЭЛЭГ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.СУВДАА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын "Эрдэнэт медикал эмнэлэг" ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын "Эрдэнэт медикал эмнэлэг" ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Өмнөх онд мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ хэсгийн хүүгийн орлогоор тайлагнаж байсан харилцагч банкны хугацаатай хадгаламжийн болон харилцах дансны үлдэгдэлд тооцож олгосон хүүгийн орлогын 254,656.0 мянган төгрөгийг тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогод оруулсан өөрчлөлт, шийдвэргүйгээр мөнгөн гүйлгээний тайлангийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ хэсгийн бусад мөнгөн орлогоор тайлагнасан,
2. Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, найдваргүй авлагыг хэрхэн бүртгэх талаар зохицуулалтгүйгээр 76,581.8 мянган төгрөгийн найдваргүй авлагын зардал бүртгэж, авлагыг бууруулсан,

612505484

D:\my doc \alban bichig\2026-A4.doc

3. Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар элэгдүүлдэг бөгөөд тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 136,343.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгөд нийт 12,869.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцож бүртгээгүй,
4. Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ хэсгийн үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгөн зарлагын дүнг 118,687.6 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн,
5. Тайланд онд 19,850.0 мянган төгрөгөөр худалдан авсан детекторын тэжээлийн блокийг бараа материалын дансаар дамжуулан зарлагадсан,
6. Холбогдох зөвшөөрөл, шийдвэр, батлагдсан төсөвгүй, үндэслэлгүйгээр 182,309.5 мянган төгрөгийн урамшуулал, нэмэгдэл хөлс тооцож олгосон,
7. Байгууллагын 2025 оны шилдэг ажилтнуудыг алдаршуулах үйл ажиллагаанд 29,120.0 мянган төгрөгийн төсөв баталж зарцуулсан,
8. Тайлант онд байгууллагын төсвөөр 952.5 мянган төгрөгийн спортын уралдаан тэмцээний хүнсний зардалд зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ", 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавapт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Компанийн тухай хуулийн 84.4-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй", 84.4.1-д "хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх", 84.4.3-д "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", 84.4.4-д "шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", НББОУС 7 "Мөнгөн гүйлгээний тайлан" стандартын 16-р параграфт "Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээг тусдаа толилуулах нь ирээдүйн олох орлого болон мөнгөн гүйлгээг бий болгох нөөцөд хамаарах зардлыг харуулдаг учраас чухал байдаг. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнд дараах зүйл хамаарна", 16-р параграфын (а)-д "үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад удаан хугацаат хөрөнгийг олж эзэмшихэд төлсөн мөнгө. Энэ төлбөрт өөрсдөө барьж байгуулсан үндсэн хөрөнгө болон капиталжих хөгжүүлэлтийн зардлууд багтана", 31-р параграфт "Хүлээн авсан ба төлсөн хүү болон ногдол ашгийн мөнгөн гүйлгээг тус бүрт нь тодруулах ёстой. Эдгээр гүйлгээ тус бүрийг үндсэн, хөрөнгө оруулалтын эсвэл санхүүгийн үйл

ажиллагааны аль нэгээр ангилж, уг ангиллаа нэг тайлант үеэс нөгөө тайлант үед тууштай мөрдөнө", НББОУС 16 "Үндсэн хөрөнгө" стандартын параграф 7-д "Үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. (а) тухайн зүйлийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг тухайн байгууллага хүртэх магадлалтай, (б) хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой", параграф 8-д "сэлбэг хэрэгсэл, нөөц тоног төхөөрөмж, үйлчилгээний тоног төхөөрөмж зэрэг зүйлсийг үндсэн хөрөнгийн тодорхойлолтыг хангасан тохиолдолд энэхүү Олон Улсын Стандартын дагуу үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Үгүй бол бараа материал гэж ангилна" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

"Эрдэнэт медикал эмнэлэг" ХХК-ийн санхүүгийн тайланд бүртгэлтэй "Медипас" ХХК-тай холбоотой 2,429,233.1 мянган төгрөгийн өглөг, 90,202.4 мянган төгрөгийн хөрөнгө дутагдлын авлагыг "Эрдэнэт медикал эмнэлэг" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлд анх тусгах үеийн алдаа гэж үзэн алдааны залруулгаар бүртгэхээр шийдвэрлэж, тус тус хасаж бүртгэжээ.

"Эрдэнэт медикал эмнэлэг" ХХК нь "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас 2023 онд авсан 0 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай 7,137,800.0 мянган төгрөгийн санхүүжилтийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх урт хугацаат зээлийн үлдэгдэл 6,185,331.9 мянган төгрөгийг компанийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс нэн даруй төлөхийг Хавдар судлалын үндэсний төвд хүргүүлсэн байна.

Тайлант онд 15,689,182.2 мянган төгрөгийн орлого олж, 15,235,299.9 мянган төгрөгийн зардал гаргаж, 454,144.2 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 7,607,054.2 мянган төгрөгөөс 10,399,759.1 мянган төгрөг болж, 2,792,704.8 мянган төгрөгөөр нэмэгджээ.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 204, 08 дугаар сарын 42 дугаар тогтоолоор "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын "Эрдэнэт медикал эмнэлэг" ХХК-ийг орон тоо, барилга байгууламж, тоног төхөөрөмж, газар эзэмших эрх болон бусад эд хөрөнгийн хамт Эрүүл мэндийн яаманд шилжүүлж, Хавдар судлалын үндэсний төвийн харьяа Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв болгон өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны А/40, Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2025 оны А/61 дүгээр тушаалаар үл хөдлөх болон бусад эд хөрөнгийг зохих журмын дагуу балансаас балансад орон тооны хамт шилжүүлэх, өр авлагын асуудлыг судлах, хүлээн авах ажлын хэсгүүдийг байгуулж, удирдамж, төлөвлөгөө баталж холбогдох ажлуудыг гүйцэтгэжээ.

D:\my doc \alban bichig\2026-A4.doc

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 12-р сарын 17-ны өдрийн 744 дүгээр тогтоолоор "Эрдэнэт медикал эмнэлэг" ХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 45,500,787.5 мянган төгрөгийн балансын үнэтэй, 17,330,686.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 4096 нэр төрлийн хөрөнгийг Эрүүл мэндийн яамны харьяа Хавдар судлалын үндэсний төв (Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв)-д шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Дээрх шийдвэр, үйл ажиллагааны дагуу болон "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 117 дугаар тогтоолд үндэслэн "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-н ерөнхий захирлын 2026 оны 01 дүгээр сарын А/15 дугаар тушаалаар тус эмнэлгийг шилжүүлэн өгөх ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэг ТӨБЗГ-ын 744 дугаар тогтоолоос хойш хөрөнгийг албан ёсоор хүлээлцэх хүртэлх хугацаанд тус эмнэлгийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхтэй холбоотойгоор гарсан санхүүгийн хүчин төгөлдөр баримт, ажил гүйлгээнд үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө, эх үүсвэрийг Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төвд хүлээлгэн өгсөн байна.

"Эрдэнэт медикал эмнэлэг" ХХК-ийн санхүүгийн тайлан, бүртгэлд тусгагдсан боловч эзэмших эрхийн гэрчилгээ нь "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын эзэмшилд байдаг 50 ширхэг орон сууц, 12 ширхэг автомашины зогсоолын үл хөдлөх хөрөнгийн эзэмших эрхийн гэрчилгээ болон, эмнэлгийн барилгын 3га газрын эрхийг шилжүүлэн өгөх бичиг баримтыг бүрдүүлэн ажиллахыг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-н СНББХ-ийн үндсэн хөрөнгийн албанд үүрэг болгосон байна.

"Эрдэнэт медикал эмнэлэг" ХХК-г татан буулгаж, Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төвийг 2026 оны 01 дүгээр сарын 20-нд улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгосон байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ПҮРЭВЛХАГВА

D:\my doc \alban bichig\2026-A4.doc

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **ХӨРӨНГӨ** | | |
| 1.1 | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 7,607,054,281.85 | 10,399,759,122.15 |
| 1.1.2 | Дансны авлага | 1,325,799,255.07 | 1,100,626,905.76 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 11,644,580.27 | 5,149,108.70 |
| 1.1.6 | Бараа материал | 1,924,499,588.16 | 1,505,822,909.15 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал /тооцоо | 48,267,776.40 | |
| 1.1.10 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **10,917,265,481.75** | **13,011,358,045.76** |
| 1.2. | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 26,754,541,273.64 | 25,116,388,259.26 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 3,856,391,942.40 | 2,865,195,729.70 |
| 1.2.10 | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **30,610,933,216.04** | **27,981,583,988.96** |
| 1.3. | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **41,528,198,697.79** | **40,992,942,034.72** |
| 2 | **Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч** | | |
| 2.1. | **ӨР ТӨЛБӨР** | | |
| 2.1.1 | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 241,607,295.28 | 50,140,250.00 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 210,725,344.00 | 0.00 |
| 2.1.1.3 | Татварын өр | 111,408,444.51 | 45,414,417.07 |
| 2.1.1.13 | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **563,741,083.79** | **95,554,667.07** |
| 2.1.2 | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 6,661,131,944.45 | 6,185,331,944.45 |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | 2,429,189,115.98 | 0.00 |
| 2.1.2.5 | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **9,090,321,060.43** | **6,185,331,944.45** |
| 2.2 | **Өр төлбөрийн нийт дүн** | **9,654,062,144.22** | **6,280,886,611.52** |
| 2.3. | **ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| 2.3.1 | Өмч : а. Төрийн | 46,769,685,718.46 | 46,769,685,718.46 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг / алдагдал / | -14,895,549,164.89 | -12,057,630,295.26 |
| 2.3.10 | Тайлангийн үеийн | 16,729,741.86 | 408,729,753.65 |
| 2.3.11 | Өмнөх үеийн | -14,912,278,906.75 | -12,466,360,048.91 |
| 2.3.20 | **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **31,874,136,553.57** | **34,712,055,423.20** |
| 2.5.20. | **Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн** | **41,528,198,697.79** | **40,992,942,034.72** |
| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
| 1 | **ХӨРӨНГӨ** | | |
| 1.1 | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 7,607,054,281.85 | 10,399,759,122.15 |
| 1.1.2 | Дансны авлага | 1,325,799,255.07 | 1,100,626,905.76 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 11,644,580.27 | 5,149,108.70 |
| 1.1.6 | Бараа материал | 1,924,499,588.16 | 1,505,822,909.15 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал /тооцоо | 48,267,776.40 | |
| 1.1.10 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **10,917,265,481.75** | **13,011,358,045.76** |
| 1.2. | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 26,754,541,273.64 | 25,116,388,259.26 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 3,856,391,942.40 | 2,865,195,729.70 |
| 1.2.10 | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **30,610,933,216.04** | **27,981,583,988.96** |
| 1.3. | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **41,528,198,697.79** | **40,992,942,034.72** |
| 2 | **Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч** | | |
| 2.1. | **ӨР ТӨЛБӨР** | | |
| 2.1.1 | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 241,607,295.28 | 50,140,250.00 |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого /цэвэр/** | 14,787,871,638.25 | 15,386,469,900.74 |
| 2 | Борлуулалтын өртөг | 11,094,048,237.85 | 11,096,438,931.64 |
| 3 | **Нийт ашиг / алдагдал /** | **3,693,823,400.40** | **4,290,030,969.10** |
| 4 | Түрээсийн орлого | 8,078,400.00 | 8,078,400.00 |
| 5 | Хүүний орлого | 399,637,779.48 | 254,656,018.02 |
| 6 | Ногдол ашгийн орлого | 0.00 | 0.00 |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | 0.00 | 0.00 |
| 8 | Бусад орлого | 20,339,790.00 | 39,977,883.55 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 140,611,534.63 | 164,592,077.03 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 3,921,183,655.46 | 3,825,287,709.97 |
| 11 | Санхүүгийн зардал | | |
| 12 | Бусад зардал | 41,512,515.60 | 148,981,153.02 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз / гарз / | 16,937.88 | 261,840.07 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз / гарз / | | |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз / гарз / | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/ | | |
| 17 | Бусад ашиг / алдагдал / | | |
| 18 | **Татвар төлөхийн өмнөх ашиг / алдагдал /** | **18,588,602.07** | **454,144,170.72** |
| 19 | Орлогын татварын зардал | **1,858,860.21** | **45,414,417.07** |
| 20 | **Татварын дараахь ашиг / алдагдал /** | **16,729,741.86** | **408,729,753.65** |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараахь ашиг /алдагдал/ | | |

| | | | |
|---|---|---|---|
| 22 | **Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал** | 16,729,741.86 | 408,729,753.65 |
| 23 | **Бусад дэлгэрэнгүй орлого** | | |
| 210202 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | |
| 210203 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| 210204 | Бусад олз /гарз/ | | |
| 24 | **Орлогын нийт дүн** | 16,729,741.86 | 408,729,753.65 |
| 25 | **Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг / алдагдал /** | | |
| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
| 1 | **Борлуулалтын орлого /цэвэр/** | 14,787,871,638.25 | 15,386,469,900.74 |
| 2 | Борлуулалтын өртөг | 11,094,048,237.85 | 11,096,438,931.64 |
| 3 | **Нийт ашиг / алдагдал /** | **3,693,823,400.40** | **4,290,030,969.10** |
| 4 | Түрээсийн орлого | 8,078,400.00 | 8,078,400.00 |
| 5 | Хүүний орлого | 399,637,779.48 | 254,656,018.02 |
| 6 | Ногдол ашгийн орлого | 0.00 | 0.00 |
| 7 | Эрхийн  шимтгэлийн орлого | 0.00 | 0.00 |
| 8 | Бусад орлого | 20,339,790.00 | 39,977,883.55 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 140,611,534.63 | 164,592,077.03 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 3,921,183,655.46 | 3,825,287,709.97 |
| 11 | Санхүүгийн зардал | | |
| 12 | Бусад зардал | 41,512,515.60 | 148,981,153.02 |
| 13 | Гадаад вальютын ханшийн зөрүүний олз / гарз / | 16,937.88 | 261,840.07 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны  олз / гарз / | | |
| 15 | Биет бус хөрөнгө  данснаас хассаны  олз / гарз / | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/ | | |
| 17 | Бусад ашиг / алдагдал / | | |
| 18 | **Татвар төлөхийн өмнөх  ашиг / алдагдал /** | **18,588,602.07** | **454,144,170.72** |
| 19 | Орлогын татварын зардал | **1,858,860.21** | **45,414,417.07** |
| 20 | **Татварын дараахь  ашиг / алдагдал /** | **16,729,741.86** | **408,729,753.65** |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараахь ашиг /алдагдал/ | | |
| 22 | **Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал** | 16,729,741.86 | 408,729,753.65 |
| 23 | **Бусад дэлгэрэнгүй орлого** | | |
| 210807 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | |
| 210809 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| **2109** | Бусад олз /гарз/ | | |
| 24 | **Орлогын нийт дүн** | 16,729,741.86 | 408,729,753.65 |
| 25 | **Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг / алдагдал /** | | |

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого /цэвэр/** | 14,787,871,638.25 | 15,386,469,900.74 |
| 2 | Борлуулалтын өртөг | 11,094,048,237.85 | 11,096,438,931.64 |
| 3 | **Нийт ашиг / алдагдал /** | **3,693,823,400.40** | **4,290,030,969.10** |
| 4 | Түрээсийн орлого | 8,078,400.00 | 8,078,400.00 |
| 5 | Хүүний орлого | 399,637,779.48 | 254,656,018.02 |
| 6 | Ногдол ашгийн орлого | 0.00 | 0.00 |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | 0.00 | 0.00 |
| 8 | Бусад орлого | 20,339,790.00 | 39,977,883.55 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 140,611,534.63 | 164,592,077.03 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 3,921,183,655.46 | 3,825,287,709.97 |
| 11 | Санхүүгийн зардал | | |
| 12 | Бусад зардал | 41,512,515.60 | 148,981,153.02 |
| 13 | Гадаад вальютын ханшийн зөрүүний олз / гарз / | 16,937.88 | 261,840.07 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз / гарз / | | |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1.1. | Мөнгөн орлогын дүн /+/ | **14,529,349,276.74** | **15,786,341,458.90** |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого | 14,500,931,086.74 | 15,430,015,525.74 |
| **120** | Бусад мөнгөн орлого | 28,418,190.00 | 356,325,933.16 |
| 1.2. | Мөнгөн зарлагын дүн /- / | **10,023,682,152.57** | **10,828,791,218.60** |
| | Ажиллагчдад төлсөн | 3,852,565,174.00 | 4,733,729,920.00 |
| 1200042 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 1,152,405,829.00 | 1,300,682,749.52 |
| **13** | Бараа материал худалдан авахад төлсөн | 2,757,378,271.65 | 2,775,833,648.90 |
| **1310** | Ашиглалтын зардалд төлсөн | 341,739,265.46 | 385,038,141.47 |
| 131001 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 19,062,600.00 | 11,238,548.00 |
| **1311** | Хүүний төлбөрт төлсөн | | 0.00 |
| 131103 | Татварын байгууллагад төлсөн | 426,980,565.26 | 707,509,506.96 |
| 131104 | Даатгалын төлбөрт төлсөн | 4,036,000.00 | 5,435,488.00 |
| 131105 | Бусад мөнгөн зарлага | 1,469,514,447.20 | 909,323,215.75 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.3 | **Үндсэн үйл ажиллаагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **4,505,667,124.17** | **4,957,550,240.30** |
| 2 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **-2,087,047,309.47** | **-1,689,045,400.00** |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн /+/ | 359,674,001.53 | 0.00 |
| | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | 0.00 |
| 210101 | Хүлээн авсан хүүний орлого | 359,674,001.53 | |
| 210102 | Хүлээн авсан ногдол ашиг | | |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн /-/ | 2,446,721,311.00 | 1,689,045,400.00 |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 1,999,091,252.00 | 1,683,545,400.00 |
| 210105 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 447,630,059.00 | 5,500,000.00 |
| 2.3 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | |
| 3 | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн /+/ | 0.00 | 0.00 |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн /-/ | 476,668,055.55 | 475,800,000.00 |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 476,668,055.55 | 475,800,000.00 |
| 3.3 | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | -476,668,055.55 | -475,800,000.00 |
| 4 | **Валютийн ханшийн зөрүү** | | |
| 5 | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | 1,941,951,759.15 | 2,792,704,840.30 |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **5,665,102,522.70** | **7,607,054,281.85** |
| **7** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **7,607,054,281.85** | **10,399,759,122.15** |
| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
| 1 | **Үндсэн үйл ажиллаагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1.1. | Мөнгөн орлогын дүн /+/ | **14,529,349,276.74** | **15,786,341,458.90** |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого | 14,500,931,086.74 | 15,430,015,525.74 |
| 210405 | Бусад мөнгөн орлого | 28,418,190.00 | 356,325,933.16 |
| 1.2. | Мөнгөн зарлагын дүн /- / | **10,023,682,152.57** | **10,828,791,218.60** |
| | Ажиллагчдад төлсөн | 3,852,565,174.00 | 4,733,729,920.00 |
| 210501 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 1,152,405,829.00 | 1,300,682,749.52 |
| 210502 | Бараа материал худалдан авахад төлсөн | 2,757,378,271.65 | 2,775,833,648.90 |
| 210503 | Ашиглалтын зардалд төлсөн | 341,739,265.46 | 385,038,141.47 |
| **2106** | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 19,062,600.00 | 11,238,548.00 |
| 210601 | Хүүний төлбөрт төлсөн | | 0.00 |
| 210603 | Татварын байгууллагад төлсөн | 426,980,565.26 | 707,509,506.96 |
| 210604 | Даатгалын төлбөрт төлсөн | 4,036,000.00 | 5,435,488.00 |
| **2107** | Бусад мөнгөн зарлага | 1,469,514,447.20 | 909,323,215.75 |
| 1.3 | **Үндсэн үйл ажиллаагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **4,505,667,124.17** | **4,957,550,240.30** |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **-2,087,047,309.47** | **-1,689,045,400.00** |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн /+/ | 359,674,001.53 | 0.00 |
| | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | 0.00 |
| 210804 | Хүлээн авсан хүүний орлого | 359,674,001.53 | |
| 210805 | Хүлээн авсан ногдол ашиг | | |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн /-/ | 2,446,721,311.00 | 1,689,045,400.00 |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 1,999,091,252.00 | 1,683,545,400.00 |
| **2109** | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 447,630,059.00 | 5,500,000.00 |
| 2.3 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | |
| 3 | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн /+/ | 0.00 | 0.00 |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн /-/ | 476,668,055.55 | 475,800,000.00 |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 476,668,055.55 | 475,800,000.00 |
| 3.3 | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | -476,668,055.55 | -475,800,000.00 |
| 4 | **Валютийн ханшийн зөрүү** | | |
| 5 | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | 1,941,951,759.15 | 2,792,704,840.30 |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **5,665,102,522.70** | **7,607,054,281.85** |
| **7** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **7,607,054,281.85** | **10,399,759,122.15** |
| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
| 1 | **Үндсэн үйл ажиллаагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1.1. | Мөнгөн орлогын дүн /+/ | **14,529,349,276.74** | **15,786,341,458.90** |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого | 14,500,931,086.74 | 15,430,015,525.74 |
| 225106 | Бусад мөнгөн орлого | 28,418,190.00 | 356,325,933.16 |
| 1.2. | Мөнгөн зарлагын дүн /- / | **10,023,682,152.57** | **10,828,791,218.60** |
| | Ажиллагчдад төлсөн | 3,852,565,174.00 | 4,733,729,920.00 |
| **9** | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 1,152,405,829.00 | 1,300,682,749.52 |
| **10** | Бараа материал худалдан авахад төлсөн | 2,757,378,271.65 | 2,775,833,648.90 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | **2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **46,769,685,718.46** | **-14,895,549,164.89** | **31,874,136,553.57** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | 2,429,189,115.98 | 2,429,189,115.98 |
| 3 | **Залруулсан үлдэгдэл** | - | | |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/ | - | 408,729,753.65 | 408,729,753.65 |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - |
| 7 | Зарласан ногдол ашиг | - | - | - |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - |
| 9 | **2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **46,769,685,718.46** | **-12,057,630,295.26** | **34,712,055,423.20** |

### 2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

| д/д | Үзүүлэлт | хэмжих нэгж | Баталсан төсөв | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Нийт орлого | сая.төг | 20,122.26 | 15,689.18 | 4,433.08 | 78.0% |
| 2 | Нийт зардал | сая.төг | 19,404.89 | 15,235.04 | 4,169.85 | 78.5% |
| 3 | Татварын өмнөх ашиг, алдагдал | сая.төг | 717.36 | 454.14 | 263.22 | 64.1% |
| 4 | Орлогын албан татварын зардал | сая.төг | 71.74 | 45.41 | 26.33 | 64.1% |
| 5 | Татварын дараах ашиг, алдагдал | сая.төг | 645.63 | 408.73 | 236.90 | 64.1% |
| 6 | Борлуулалтын 1 төгрөгт оногдох зардал | сая.төг | 0.96 | 0.97 | -0.01 | 101.0% |
| 7 | Нийт ажилтны тоо | хүн | 177 | 164 | 13.00 | 92.7% |
| 8 | Нийт цалингийн сан | сая.төг | 6,034.80 | 5,741.20 | 293.60 | 95.1% |
| 9 | Хөрөнгө оруулалт | сая.төг | 2,519.27 | 1,519.30 | 999.97 | 60.3% |

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 719,767.0 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 2,194.8 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 210,429.5 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 507,142.7 мянган төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

Цалинг 1,000.0 мянган төгрөгөөр илүү олгосон, кассаас анхан шатны баримтгүй 242.3 мянган төгрөг зарцуулсан, байгууллагын төсвөөр 952.5 мянган төгрөгийн спортын уралдаан тэмцээний хүнсний зардалд зарцуулсан зэрэг нийт 2,194.7 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоосон.

### 3.2 Албан шаардлага

Байгууллагын 2025 оны шилдэг ажилтнуудыг алдаршуулах үйл ажиллагаанд 29,120.0 мянган төгрөгийн төсөв баталж зарцуулсан, ажилтнуудын цалин, ээлжийн амралтын цалинг 27,809.4 мянган төгрөгөөр давхардуулан тооцож олгосон, гүйцэтгэх захирлын А/107 дугаар тушаалаар нийт ажилтнуудад 153,500.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон зөрчлүүдэд 3 албан шаардлага хүргүүллээ.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлан, бүртгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт*:

2024 онд мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ хэсгийн хүүгийн орлогоор тайлагнаж байсан харилцагч банкны хугацаатай хадгаламжийн болон харилцах дансны үлдэгдэлд тооцож олгосон хүүгийн орлогын 254,656.0 мянган төгрөгийг тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогод оруулсан өөрчлөлт, шийдвэргүйгээр мөнгөн гүйлгээний тайлангийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ хэсгийн бусад мөнгөн орлогоор тайлагнасан байна.

Энэ нь НББОУС 7 "Мөнгөн гүйлгээний тайлан" стандартын 31-р параграфт "Хүлээн авсан ба төлсөн хүү болон ногдол ашгийн мөнгөн гүйлгээг тус бүрт нь тодруулах ёстой. Эдгээр гүйлгээ тус бүрийг үндсэн, хөрөнгө оруулалтын эсвэл санхүүгийн үйл ажиллагааны аль нэгээр ангилж, уг ангиллаа нэг тайлант үеэс нөгөө тайлант үед тууштай мөрдөнө" гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Хүүгийн орлогын бүртгэлийн бодлогоо нэг тайлант үеэс нөгөө тайлант үед тууштай мөрдөх.

2. Санхүүгийн тайлан, бүртгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт*:

Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, найдваргүй авлагыг хэрхэн бүртгэх талаар зохицуулалтгүй боловч эрүүл мэндийн даатгалаар тусламж үйлчилгээ үзүүлсэн орлогоос нэхэмжлэлийн чанарын хяналтаар хасагдсан 2023-2025 оны 68,742.3 мянган төгрөг, хэвтэн эмчлүүлсэн тусламж үйлчилгээний төлбөрийг төлөөгүй 6 иргэний 2024-2025 оны 2,141.0 мянган төгрөг, 2022 онд үүссэн ПОС машины орлоготой холбоотой “Медипас” ХХК-аас авах 5,698.5 мянган төгрөг, нийт 76,581.8 мянган төгрөгийг тайлант онд найдваргүй авлагын зардлаар бүртгэж авлагыг бууруулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний орлогыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан "Чанар, төлбөрийн хяналтын журам"-ын хүрээнд хасагдсан дүнгээр бууруулж үйл ажиллагааны орлогыг бодитой бүртгэж, найдваргүй авлага үүсгэхгүй байх.

3. Санхүүгийн тайлан, бүртгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт*:

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар элэгдүүлдэг бөгөөд тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 136,343.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгөд нийт 12,869.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцож бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", НББОУС 16-д "Хөрөнгийн элэгдүүлэх өртөг нь ашиглалтын хугацааны туршид системтэйгээр хуваарилагдана" гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Байгууллагын өмчлөлд шилжсэн үндсэн хөрөнгийн элэгдлийг, элэгдэл тооцох хугацааны туршид бүрэн гүйцэд тооцож элэгдүүлэх.

4. Санхүүгийн тайлан, бүртгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт*:

Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ хэсгийн үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгөн зарлагын дүнг 118,687.6 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", НББОУС 7 "Мөнгөн гүйлгээний тайлан" стандартын 16-р параграфт "Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээг тусдаа толилуулах нь ирээдүйн олох орлого болон мөнгөн гүйлгээг бий болгох нөөцөд хамаарах зардлыг харуулдаг учраас чухал байдаг. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнд дараах зүйл хамаарна", 16-р параграфын (а)-д "үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад удаан хугацаат хөрөнгийг олж эзэмшихэд төлсөн мөнгө. Энэ төлбөрт өөрсдөө барьж байгуулсан үндсэн хөрөнгө болон капиталжих хөгжүүлэлтийн зардлууд багтана" гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгөн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайлангийн холбогдох хэсэгт үнэн зөв илэрхийлж байх.

5. Нийт зардалтай холбоотой асуудал

*Илрүүлэлт*:

Тайланд онд 19,850.0 мянган төгрөгөөр худалдан авсан Детекторын тэжээлийн блокийг бараа материалын дансаар дамжуулан зарлагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.2-д "Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх аж ахуйн нэгж ...", 4.2.4-д "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж", 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", НББОУС 16 "Үндсэн хөрөнгө" стандартын параграф 7-д "Үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө.

а. тухайн зүйлийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг тухайн байгууллага хүртэх магадлалтай

б. хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой", параграф 8-д "сэлбэг хэрэгсэл, нөөц тоног төхөөрөмж, үйлчилгээний тоног төхөөрөмж зэрэг зүйлсийг үндсэн хөрөнгийн тодорхойлолтыг хангасан тохиолдолд энэхүү Олон Улсын Стандартын дагуу үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Үгүй бол бараа материал гаж ангилна" гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор ашиглагдах энгийн сэлбэг хэрэгслийг бараа материалд бүртгэж, ашиглах үед зардалд тусгах, харин нэгээс дээш жилийн хугацаанд ашиглагдах, тодорхой үндсэн хөрөнгөд зориулсан томоохон сэлбэг, эд ангийг үндсэн хөрөнгөөр бүртгэж, ашиглалтын хугацаанд элэгдэл тооцох.

6. Нийт зардалтай холбоотой асуудал

*Илрүүлэлт*:

Тус эмнэлгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэг нийлүүлэгчээс худалдан авч болох ижил төрлийн барааг тус тусад нь арга хэмжээ болгон шууд худалдаж авахаар төлөвлөж, баталж байна. Тухайлбал: Шатахуун - 17,482.0 мянган төгрөг, автомашины тос, тосолгооны материал 7,015.9 мянган төгрөг.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Нэг нийлүүлэгчээс худалдан авах боломжтой шатах, тослох материалыг нэг төсөл арга хэмжээгээр төлөвлөж, худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулах.

7. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

*Илрүүлэлт*:

Худалдан авах ажиллагааны архивын баримтын хадгаламжийн нэгжид бараа хүлээн авсан актыг оруулаагүй байна. Мөн шууд худалдан авалтын хадгаламжийн нэгж нь тухайн худалдан авалттай холбоотой баримтын бүрдэл дутуу, эмх цэгцгүй үдэгдсэн байна.

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 3.1-д "Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална", 3.1.2-д "бүрдүүлэлт тогтмол, бүрэн байх", 35.4.1-д "байгууллагын үйл ажиллагааг холбогдох журам, стандартын дагуу баримтжуулах", 35.4.3-т "баримт бичгийн эмх цэгц, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах", 36.1-д "Байгууллагын үйл ажиллагааг баримтжуулахад дараах шаардлагыг хангаж ажиллана", 36.1.4-д "баримт бичгийг мэдээллийн эх сурвалж, хуулийн хүчинтэй байх шаардлагад нийцүүлэн зохиож хөтлөх", 46.2-т "Байгууллагын зохион байгуулалтын нэгжийн удирдлага болон бичиг хэргийн ажилтан албан хэрэг хөтлөлтийн шатанд баримт бичгийн эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг хариуцах бөгөөд тэдгээрт байгууллагын удирдлага хяналт тавина", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48.4-д "Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана", 48.4.11-д "бусад баримт бичиг гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Худалдан авах ажиллагааны архивын баримтыг иж бүрэн хангах, тендер шалгаруулалтын хувийн хэрэгт бараа хүлээн авсан актыг хавсаргах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант онд 1 албан хаагчид 1,000.0 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна. | 1 | 1,000.0 | 1 | 1,000.0 | | | | | | | | |
| Тайлант онд анхан шатны нотлох баримтгүй 242.3 мянган төгрөг кассаас зарцуулсан байна. | 1 | 242.3 | 1 | 242.3 | | | | | | | | |
| Тайлант онд байгууллагын төсвөөр 952.5 мянган төгрөгийн спортын уралдаан тэмцээний хүнсний зардалд зарцуулсан байна. | 1 | 952.5 | 1 | 952.5 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 114 жил, Ардын хувьсгалын 104 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2025.07.09-ны өдрийн А/107 дугаар тушаалаар нийт ажилтнуудад 153,500.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон мөн Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв болон шилжихтэй холбоотой ажлын ачаалал их байсан гэж үзэж ажилтнуудад 27,809.4 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг өгч нийт 181,309.5 мянган төгрөгийн урамшуулал, ээлжийн амралтын цалинг хавтгайруулж олгосон байна. | 2 | 181,309.5 | | | 2 | 181,309.5 | | | | | | |
| Тус байгууллагын 2025 оны шилдэг ажилтнуудыг алдаршуулах үйл ажиллагаанд 29,120.0 мянган төгрөгийн төсөв баталж зарцуулсан байна. | 1 | 29,120.0 | | | 1 | 29,120.0 | | | | | | |
| Өмнөх онд мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ хэсгийн хүүгийн орлогоор тайлагнаж байсан харилцагч банкны хугацаатай хадгаламжийн болон харилцах дансны үлдэгдэлд тооцож олгосон хүүгийн орлогын 254,656.0 мянган төгрөгийг тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогод оруулсан өөрчлөлт, шийдвэргүйгээр мөнгөн гүйлгээний тайлангийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ хэсгийн бусад мөнгөн орлогоор тайлагнасан байна. | 1 | 254,656.0 | | | | | 1 | 254,656.0 | | | | |
| Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, найдваргүй авлагыг хэрхэн бүртгэх талаар зохицуулалтгүй боловч эрүүл мэндийн даатгалаар тусламж үйлчилгээ үзүүлсэн орлогоос нэхэмжлэлийн чанарын хяналтаар хасагдсан 2023-2025 оны 68,742.3 мянган төгрөг, хэвтэн эмчлүүлсэн тусламж үйлчилгээний төлбөрийг төлөөгүй 6 иргэний 2024-2025 оны 2,141.0 мянган төгрөг, 2022 онд үүссэн ПОС машины орлоготой холбоотой Медипас ХХК-аас авах 5,698.5 мянган төгрөг, нийт 76,581.8 мянган төгрөгийг тайлант онд найдваргүй авлагын зардлаар бүртгэж авлагыг бууруулсан байна. | 1 | 76,581.8 | | | | | 1 | 76,581.8 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар элэгдүүлдэг бөгөөд тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 136,343.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгөд нийт 12,869.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцож бүртгээгүй байна. | 1 | 12,869.4 | | | | | 1 | 12,869.4 | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ хэсгийн үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгөн зарлагын дүнг 118,687.6 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн байна. Үүнд: Хангамжийн зүйлсийн 91,564.8 мянган төгрөг зэрэг багтаж байна. | 1 | 118,687.6 | | | | | 1 | 118,687.6 | | | | |
| Тайланд онд 19,850.0 мянган төгрөгөөр худалдан авсан Детекторын тэжээлийн блокийг бараа материалын дансаар дамжуулан зарлагдсан байна. | 1 | 19,850.0 | | | | | 1 | 19,850.0 | | | | |
| Тус эмнэлгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэг нийлүүлэгчээс худалдан авч болох ижил төрлийн барааг тус тусад нь арга хэмжээ болгон шууд худалдаж авахаар төлөвлөж, баталж байна. Тухайлбал: Шатахуун - 17,482.0 мянган төгрөг, автомашины тос, тосолгооны материал 7,015.9 мянган төгрөг. | 1 | 24,497.9 | | | | | 1 | 24,497.9 | | | | |
| Худалдан авах ажиллагааны архивын баримтын хадгаламжийн нэгжид бараа хүлээн авсан актыг оруулаагүй байна. Мөн шууд худалдан авалтын хадгаламжийн нэгж нь тухайн худалдан авалттай холбоотой баримтын бүрдэл дутуу, эмх цэгцгүй үдэгдсэн байна. | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 | | | | |
| **Дүн** | **13** | **719,767.0** | **3** | **2,194.8** | **3** | **210,429.5** | **7** | **507,142.7** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй. Нийт 12 мэдээллийг хугацаа хоцроож, 35 мэдээллийг огт мэдээлээгүй орхигдуулсан байна. | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Дүн | 1 | 0 | | | 1 | 0 | | |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | | **1** | | |